

**НОЁН СУМААС СУХАЙТ ХҮРТЭЛХ 20 КМ САЙЖУУЛСАН ШОРООН ЗАМ  
/ӨМНӨГОВЬ, НОЁН СУМ/-ЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
АЖЛЫН ДААЛГАВАР**

2019 оны 03 сарын 28-ны өдөр

09/19

Улаанбаатар хот

1. Зураг төсөл боловсруулах  
үндэслэл  
  
Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хуулийн  
2-р хавсралт, XIII.1.1.51 заалт, Зам, тээврийн  
хөгжлийн сайдын 2019 оны 01 дүгээр сарын 09-  
ний өдрийн 07 дугаар тушаалд тусгагдсаны дагуу
2. Байршил  
  
Өмнөговь аймаг, Ноён сум
3. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр  
  
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар
4. Замын техникийн ангилал, замын зэрэг,  
хүчин чадал  
  
Замын ангилал ЗА
5. Замын хучлага  
  
Тооцоогоор
6. Хучилтын бүтээц  
  
Тооцоогоор
7. Төлөвлөлтийн норм  
  
  - “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016
  - “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД  
32-02-12;
  - “Авто замын уур амьсгал, геотехникийн  
нэхцэл” АЗУАГН 2.01.01-2004
  - “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга  
төлөвлөх” БНБД 22.01.01\*/2006
  - Авто замын уур амьсгал, геотехникийн  
нэхцэл” АЗУАГН 2.01.01-2004
  - “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга  
төлөвлөх” БНБД 22.01.01\*/2006
  - “Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд  
зориулсан замыг төлөвлөх заавар” MNS  
6056:2009
  - Хот суурины гудамж зам төлөвлөлт” БНБД  
32-01-04
8. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа  
  
Нарийвчилсан зураг төслийг 2019 оны 04  
дүгээр сард багтаан гүйцэтгэнэ
9. Зураг төслийн иж бүрдэл  
  
  - “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016-  
ийн хавсралт 2-8-ыг баримтлана.
  - Инженер-геологийн судалгааны ажлын  
тайлан Карьерын судалгаа /Зам барилгын

ажилд хэрэглэх дүүргэгч материал тус бүрээр/

- Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, "Геодезийн ажил" БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах;
- Инженерийн нарийвчилсан зураг
- Геодезийн хэмжилтийн тайлан
- Хучилтын тооцоо
- Зургийн тайлбар бичиг
- Техникийн шаардлага
- Авто замын трасст орсон шугам сүлжээг шилжүүлэх ажлын зураг төсөл
- Ус зайлзуулах байгууламжийн тооцоо
- Ажлын нэр төрөл, тоо хэмжээ Барилгын ажлын нэгдсэн төсөв
- Ажил гүйцэтгэх аргачлал
- Байгаль орчинд нөлөөлэх байдлын нарийвчилсан үнэлгээ
- Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан Магадлалын өрөнхий дүгнэлт
- Зам барилгын ажилтай холбоотой газар олгосон орон нутгийн засаг захиргааны захирамж болон бусад зөвшөөрлүүд

#### 10. Зураг төслийн байгууллага

Хөрөнгө оруулагч сонгон шалгаруулна.

#### 11. Захиалагч байгууллага

Зам, тээврийн хөгжлийн яам

#### 12. Онцгой нөхцөл

- Авто замын эхлэлийг тухайн орон нутгийн ЗДТГ болон орон нутгийн зам, засвар арчлалтын байгууллагатай зөвшилцэж, Захиалагчид танилуулах;
- Трассыг сонгоходоо сум, суурингийн төвийг тойруулах, тэдгээр рүү гарах гарцыг зохих нормын дагуу төсөллөх.
- Замын трасс болон хучилтын хийцийг сонгоходоо Төслийн бүсэд байгаа бусад үйлдвэр, уурхайн бүтээгдэхүүний болон бүс, орон нутгийн авто тээврийн хэрэгсэл зорчих хөдөлгөөний урсгалыг тооцох.
- Замын трассын дагуу 2 км тутамд хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхлэх, геодезийн хэмжилтийг UTM системд хийж гүйцэтгэх;
- Зам, гүүрийн зурваст орсон болон доогуур хөндлэн өнгөрч байгаа инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай

тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардлыг тооцож зураг төсөлд тусгах;

- Замын зурваст археологийн тандалт, судалгаа хийх, авран хамгаалах малталт хийлгэх ажлын хэмжээ, өргтийг төсөвт тусгах;
- Шаардлагатай хэсгүүдэд төлөвлөгдж буй замыг хөндлөн гарах мал, амьтны гарц төлөвлөх;
- Ухмал ба зам дээр цас хунгарлахаас сэргийлэх далангийн шийдлийг төсөллөх;
- Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох;
- Хөдөлгөөний аюулгүй байдлын аудитын дүгнэлт гаргах, тэмдэг, тэмдэгжилтийн талаар тухайн холбогдох байгууллагаас санал авах;
- Замын хөдөлгөөнийг зохион байгуулах техник хэрэгсэл, тоноглолтыг оновчтой төлөвлөх;
- Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөвт тусгах;
- Тээврийн хэрэгслийн зогсоолтыг холбогдох стандартын дагуу төсөллөх;

Хянасан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга


Зам тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын  
Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга

Боловсруулсан:

Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн



Д.ДОРЖХАНД



Х.ОРГИЛ-ЭРДЭНЭ



Д.ЭНХТУЯА